



**СОНГОЛОН ХАЙРХАН ХХК-ИЙН
ИХ БУЛАНГИЙН ЭЛС ХАЙРГАНЫ ОРДЫН
2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**
(Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сум)
Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-017362



Улаанбаатар хот
2025 он



АГУУЛГА

ОРШИЛ V

БҮЛЭГ 1. ОРДЫН ТАНИЛЦУУЛГА	1-1
1.1 КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ	1-1
1.2 ОРДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	1-1
1.2.1 Ордын байршил, орчны тойм зураг	1-1
1.3 ҮНДСЭН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	1-1
1.4 АЖИЛЛАХ ГОРИМ, АЖИЛЛАХ ХҮЧ	1-2
1.5 ХҮЧИН ЧАДАЛ	1-3
1.6 ДЭД БҮТЭЦ	1-4
БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	2-1
2.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	2-2
2.1.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	2-2
2.1.2 Хөрсөн бүрхэвч, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	2-3
2.1.3 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	2-4
2.1.4 Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	2-4
2.2 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	2-5
2.3 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	2-6
2.4 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	2-6
2.5 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	2-6
2.6 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	2-7
2.7 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	2-8
2.8 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	2-10
2.9 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	2-16

ДҮГНЭЛТ А

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1-1. Уулын ажлын механикжуулалт	1-2
Хүснэгт 1-2. Ажиллах хүч	1-2
Хүснэгт 1-3. Уурхайн ажиллах горим	1-3
Хүснэгт 1-4. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө	1-3
Хүснэгт 1-5. Их Булангийн элс хайрганы ордын геологийн нөөцийн тооцоо	1-4
Хүснэгт 2-1. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй	2-1
Хүснэгт 2-2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт	2-2



Хүснэгт 2-3. Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт	2-3
Хүснэгт 2-4. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт	2-4
Хүснэгт 2-5. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт	2-5
Хүснэгт 2-6. Ногоон байгууламжийн төлөвлөгөөний хэрэгжилт	2-5
Хүснэгт 2-7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт	2-6
Хүснэгт 2-8. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	2-7
Хүснэгт 2-9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	2-8
Хүснэгт 2-10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт	2-10
Хүснэгт 2-11. Уурхайн орчимд хийсэн агаарын хэмжилтийн үр дүн.....	2-11
Хүснэгт 2-12. Агаарын хэмжилтийн дүн, 8-р сар	2-13
Хүснэгт 2-13. Уурхайн талбайгаас авсан хөрсний дээжийн хариу	2-13
Хүснэгт 2-14. Карьерын талбайн орчимд бүртгэгдсэн ургамлын жагсаалт	2-15
Хүснэгт 2-15. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт	2-17

Графикийн жагсаалт

График 2-1. Уурхайд хийгдсэн хүхэрлэг хийн агууламж	2-11
График 2-2. Уурхайд хийгдсэн азотын давхар ислийн агууламж	2-12
График 2-3. Уурхайд хэмжигдсэн нийт тоосны агууламж	2-12
График 2-4. Хөрсөнд агуулагдах Нитратын хэмжээ	2-14
График 2-5. Хөрсөнд агуулагдах Сүльфатын хэмжээ	2-14

Зургийн жагсаалт

Зураг 1-1. Их Булангийн элс хайрганы ордын байршил	1-1
Зураг 2-1. Тээврийн хэрэгслийн гэрчилгээ	2-2
Зураг 2-2 Цэвэрлэгээ хийгдэж буй үйл явц	2-4
Зураг 2-3 Орчны цэвэрлэгээ хийгдэж байна	2-4
Зураг 2-4 Мод усалж буй процесс	2-5
Зураг 2-5. Ажилчд сургалтад хамрагдаж байгаа байдал	2-7
Зураг 2-6 Ажилчдын эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байдал.....	2-8
Зураг 2-7 Хогийн цэг, түүний ойр орчим цэвэрлэгээ хийж буй байдал.....	2-9
Зураг 2-8 Хог хаягдал тээвэрлэх байгууллагад төлсөн баримт.....	2-9
Зураг 2-9. Хог хаягдал тээвэрлэх хамтран ажиллах гэрээ.....	2-10
Зураг 2-10. Хог хаягдлын бүртгэлийн хуудас.....	2-10
Зураг 2-11. Агаарын чанарын хэмжилт, 8 сар	2-13
Зураг 2-12 Хөрсний дээж	2-13
Зураг 2-13. Ургамлын мониторинг хийх явц	2-15
Зураг 2-14Ажилчдын эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан хуудас.....	2-18



Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Зураг 2-15. Ажилчдад сургалтад хамрагдаж буй байдал2-18



Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

ОРШИЛ

“Сонголон Хайрхан” ХХК нь Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт орших Их булангийн элс, хайрганы ордод 2022 онд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотголын тайланг “Баялаг Эко” ХХК-аар боловсруулж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамаар батлуулсан. Улмаар тус компани 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулжээ.

2025 оны БОМТ-д тусгагдсан байгаль орчныг хамгаалах болон хяналт-шинжилгээний ажлуудыг хэрэгжүүлж, тэдгээрийн биелэлтийн тайланг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаалын 4.1-д заасан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулсан болно.



БҮЛЭГ 1. ОРДЫН ТАНИЛЦУУЛГА


1.1 КОМПАНИЙН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Төслийн нэр	Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Их булангийн элс хайрганы орд
Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж байгууллага	- Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: Сонголон Хайрхан ХХК - Улсын бүртгэлийн дугаар: 9011179051 - Регистрийн дугаар: 5276764 - Хаяг: Дархан-Уул аймаг, Дархан сум, 13-р баг - Утас: +976 98009669 +976 99220394 - Цахим шуудан: songolon_h@yahoo.com

1.2 ОРДЫН ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1.2.1 Ордын байршил, орчны тойм зураг

Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын талбай нь Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлана. Ордын талбайн хэмжээ 100.53 га бөгөөд байршлыг Зураг 1-1-т тусгав.



Зураг 1-1. Их Булангийн элс хайрганы ордын байршил

1.3 ҮНДСЭН ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Их булангийн элс-хайрганы ордын ашиглалтын гүн их биш, уул-геологийн нөхцөл энгийн тул тээвэртэй ашиглалтын системээр, ил аргаар ашиглана. Усны түвшнөөс дээш элс-хайрга олборлолтыг “экскаватор-автосамосвал”-ын хослолоор явуулна. Усны түвшнөөс доош олборлолтод экскаватор-автосамосвал”-ын хослол дээр нэмэлтээр элс-хайрга сорогч машинаар



(дреджер) олборлолт явуулна. Мөн төсөлд ил уурхайгаас олборлосон элс-хайргыг шигшиж 10 мм ээс дээш ширхэглэхтэй хайргыг бутлахаар тусгасан ба шигшүүр, бутлуур болон туузан конвейер ашиглах төлөвлөсөн байна. Уулын ажлын механикжуулалтыг Хүснэгт 1-1-д тусгав.

Хүснэгт 1-1. Уулын ажлын механикжуулалт

№	Үндсэн тоног төхөөрөмж	Ажиллах объект	Тоо	Хүчин чадал		Ашиглалтад орсон он
				Нэгж	Хэмжээ	
1.	Экскаватор /Hyundai 290LC, 1.3 м/	Элс-хайрга олборлолт	1	м³	1.3	2014
2.	Дреджер /YUJSD250, 200 м³/	Элс-хайрга олборлолт	1	м³/цаг	200	
3.	Ачигч /ZL-50/	Тээврийн хэрэгсэлд ачих, шигшүүрийн бункер тэжээх	1	тн	25	2014
4.	Автосамосвал /Hyundai HD-270, 25тн/	Элс-хайрга тээвэр	2	м³	3	2014
5.	Бульдозер /Shantui SD-23/	Хөрс хуулга, овоолго	1	м³	6	2014
6.	Доргиурт шигшүүр /ЗУК-1245/	Элс-хайрга шигших	1	тн/ц	15-80	
7.	Хацарт бутлуур /PE 150x250/	Элс-хайрга бутлах	1	тн/ц	70-150	
8.	Туузан конвейер	Нунтаг материалыг зөөвөрлөх	1	тн/ц	30-60	

Экскаватор нь элс-хайрга олборлолтод ажиллахаас гадна уурхайн ашиглалтын эхний жилийн хөрс хуулалтын ажлыг гүйцэтгэж элс-хайрганы нөөцийг нээж олборлолтод бэлдэнэ. Ашиглалтын 2 дахь жилээс уурхайн хучаас хөрсний зузаан 0.5-1 м, хөрс хуулалтын хэмжээ харьцангуй бага тул бульдозероор уурхайн ашиглалтын талбайн нэг тийш түрж хуулан, буцаан олборлосон орон зайг дүүргэх боломжтой.

1.4 АЖИЛЛАХ ГОРИМ, АЖИЛЛАХ ХҮЧ

Уурхай нь улирлын чанартайгаар 5-р сарын 15-наас 10-р сарын 15 хүртэл хоногт 10 цагийн үргэлжлэлтэй 1 ээлжээр ажиллана. Төслийн талбайд нийт 25 хүн ажиллах ба уурхайн ажиллах хүчийг Хүснэгт 1-2-д тусгав.

Хүснэгт 1-2. Ажиллах хүч

№	Албан тушаал	Орон тоо	Ажиллах хэсэг
1.	Уурхайн дарга	1	Инженер техникийн ажилчид
2.	Уурхайн мастер	1	
3.	Экскаваторын оператор	1	
4.	Автосамосвалын жолооч	2	Уулын хэсэг
5.	Бульдозерын оператор	2	
6.	Утгуурт ачигчийн оператор	1	
7.	Дреджерийн оператор	1	
8.	Тех ажилчид	4	Үйлдвэрийн хэсэг
9.	Засварчин	1	
10.	Цахилгаанчин	1	
11.	Гагнуурчин	1	
12.	Нягтлан бодогч	1	Захиргаа аж ахуйн хэсэг
13.	Нярав	1	
14.	Жолооч үйлчилгээний	1	
15.	Ах тогооч	1	
16.	Тогооч	1	



Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

№	Албан тушаал	Орон тоо	Ажиллах хэсэг
17.	Үйлчилгээний туслах ажилчин	2	
18.	Хамгаалагч	1	
19.	Сахиул	1	
	Нийт	25	4 хэсэг

Дээрх хүснэгтээс харахад инженер техникийн ажилчид 2 хүн, уулын хэсгийн ажилчид 7 хүн, үйлдвэрийн хэсэгт 7 хүн ажиллах ба захиргаа аж ахуйн хэсэгт 9 хүн ажиллаж нийт 25 хүний ажиллах хүчтэй байна.

Уурхайн ажиллах горимыг тооцоолохдоо бүх нийтийн амралтын өдрүүд болон цаг агаарын гэнэтийн тааламжгүй нөхцөлийн үед ажил саатах хоногийг хасаж тооцоолсон ба тоног төхөөрөмжийн урсгал болон үндсэн засварын хугацааг тоног төхөөрөмжийн төрөл зүйл, хүчин чадлаас хамааруулан тооцоонд хасаж өгсөн байна. Төсөлд уурхайн жилд ажиллах хоногийг дараах байдлаар тогтоосон байна. Уурхайн ажиллах горимыг Хүснэгт 1-3-д тусгав.

Хүснэгт 1-3. Уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлт	Нэгж	Тоо, хэмжээ
1.	Жилд ажиллах боломжит хоног	хоног	149
2.	Цаг агаарын хүндрэл	хоног	3
3.	Амралт, баяр ёслол	хоног	5
4.	Хоногт, ажиллах ээлжийн тоо	хоног	1
5.	Ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	10
6.	Ажиллагсдын тоо	хүн	25
7.	Уурхайн ажиллах хоног	хоног	149-3-6=140

Дээрх хүснэгтээс харахад улсын чанартай амралт, баяр ёслолын өдрүүд 5 хоног байна. Цаг агаарын хүндрэлийг тооцоолсон өдрүүд 3 хоног байна. Хоногийн нэг ээлжид ажиллах хүний тоо 1 бөгөөд нэг ээлжийн үргэлжлэх хугацаа 10 цаг байх ба уурхайн жилд ажиллах өдрүүд 140 хоног байна.

1.5 ХҮЧИН ЧАДАЛ

Уг элс хайрганы орд нь жилд 30 мян.м³ элс хайрга олборлох хүчин чадалтай. Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөөг Хүснэгт 1-4-д тусгав. Төслийн ТЭЗҮ-д уурхайн ашиглалтын жилийг тооцоолохдоо уулын ажлын 30 жил хүртэл 5 жилээр, 6 үе шатаар төлөөлүүлэн ажлын календарьчилсан төлөвлөгөөг боловсруулсан байна.

Хүснэгт 1-4. Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ашиглалтын жилүүд						Нийт
			1-5	6-10	11-15	16-20	21-25	26-30	
1.	Элс-хайрга	мян.м ³	162.08	150.43	172.07	149.73	162.46	147.78	944.54
2.	Хөрс	мян.м ³	70.57	32.81	50.99	63.13	44.83	135.81	398.14
3.	Уулын цул	мян.м ³	232.65	183.24	223.06	212.85	207.29	283.6	1342.68
4.	Овоолго /Кс= 1.33/	мян.м ³	93.86	43.63	67.81	83.96	59.62	180.63	529.52

Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөөнд тусгаснаар уурхайн ашиглалтын 30 жилийн хугацаанд уурхайн үйлдвэрлэлийн нөөц 944.5 мян.м³ элс-хайрга байна. Хөрс хуулалтын хэмжээ 398.14 мян.м³ үүнээс сийрэгжилт тооцсоноор овоолгод 529.52 мян.м³ хөрс байршуулна.

Ашиглалтын нөөц. Ордын үйлдвэрлэлийн нөөцийн тооцоог Хүснэгт 1-5-д тусгав.



Хүснэгт 1-5. Их Булангийн элс хайрганы ордын геологийн нөөцийн тооцоо

№	Нөөцийн блок	Элс хайрганы нөөц, м ³		
		Элс хайрганы нөөц, м ³	Үүнээс:	
			Элс	Хайрга
1.	В-I	1,634,273	1,358,081 /83.1%/	276,192 /16.9%/
	а. Усны төвшнөөс дээш	372,316	309,395	62,921
	б. Усны төвшнөөс доош	1,261,957	1,048,686	213,271
2.	В-II	1,917,235	1,560,629 /81.4%/	356,606 /18.6%/
	а. Усны төвшнөөс дээш	256,241	208,580	47,661
	б. Усны төвшнөөс доош	1,660,994	1,352,049	308,945
Нийт		3,551,508	2,918,710	632,798
	а. Усны төвшнөөс дээш	628,557	517,975	110,582
	б. Усны төвшнөөс доош	2,922,951	2,400,735	522,216

Уурхайн үйлдвэрлэлийн нөөцийн тооцоог ордын нийт нөөцийн хэмжээнд авч үзвэл нийт 3325.44 мян.м³ элс-хайрганы нөөцтэй байна.

1.6 ДЭД БҮТЭЦ

Усан хангамж: Ажилчид уурхайн талбайд байрлахгүй бөгөөд зөвхөн ажлын цагаар олборлолт явуулна. Ажилчид Сонголон Хайрхан ХХК-ийн бетон зуурмагийн үйлдвэрийн харьяанд байрлах ажилчдын байранд байрлана.

Уурхайн ахуйн ус хангамжийг Дархан-Ус суваг ХК-тай байгуулсан цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах гэрээгээр зохицуулна.

Цахилгаан хангамж: ДСЦТС ХК-ийн 35/6 кВ элсэн карьер дэд станцаас тмз-1600/35/0,4 төрлийн бууруулах трансформатор ашиглан эрчим хүч татах ажил хийгдэж байна.



БҮЛЭГ 2. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

БОМТ нь байгаль хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэх бөгөөд байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байхаар, орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө, зардал, хугацааг тодорхойлон тусгахаар хуульчлагдсаныг баримтлан БОХТ, ОХШХ-ийг боловсруулсан.

Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын 2025 оны БОМТ-г авч хэрэгжүүлэхэд 11,195,000 төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна. 2025 оны БОМТ-ний зардлын хураангуйг Хүснэгт 2-1-д тусгав.

Хүснэгт 2-1. 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хураангуй

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал, ₮
1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	860,000
2.	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	1,550,000
3.	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
4.	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
5.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
6.	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,645,000
7.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	360,000
8.	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	6,000,000
9.	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	780,000
Нийт зардал		11,195,000



Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

2.1 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

БОННУ тайланд Их Булангийн элс хайрганы ордын үйл ажиллагаанаас агаарын чанарт дараах гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл гарахыг дурдсан. Үүнд:

- Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр тоосжилт үүсэх
- Тээврийн хэрэгслүүдийн түлшний шаталт агаар орчныг бохирдуулж болзошгүй


Эдгээр сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор 2025 оны БОМТ-д дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд хэрэгжилтийн явцыг Хүснэгт 2-2-д харуулсан. Үүнд:

- Уурхайн тээвэрлэлтийн замын тоосжилтыг бууруулахын тулд усалгаа хийх
- Уурхайд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслээс ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах, хуваарьт үзлэг, оношилгоонд тогтмол хамруулах

Хүснэгт 2-2. Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Уурхайн тээвэрлэлтийн замын тоосжилтыг бууруулахын тулд усалгаа хийх	Уурхайн 1.2 км урт тээврийн замын 2025 оны 5–9 дугаар сард үүсэх тоосжилтыг бууруулах зорилгоор усалгааг тогтмол хийсэн. Усалгааны үр дүнд замын хөдөлгөөний үеийн тоосжилт мэдэгдэхүйц буурсан.	100%
2.	Уурхайд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслээс ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах, хуваарьт үзлэг, оношилгоонд тогтмол хамруулах	Уурхайд ашиглагдаж буй экскаватор, ковшийг ялгарах хорт утааг хянах, агаарын чанарыг үнэлэх ажлыг хийсэн. Бүх төхөөрөмж стандартын дагуу шалгагдсан.	100%

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны холбогдох зургуудыг доор тусгалаа.



Зураг 2-1. Тээврийн хэрэгслийн гэрчилгээ



2.1.2 Хөрсөн бүрхэвч, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

БОННУ тайланд тусгаснаар Их Булангийн элс хайрганы ордын үйл ажиллагаанаас хөрсөн бүрхэвч, газрын гадаргад дараах гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг үзүүлэхээр байна. Үүнд:

- Хөрсний элэгдэл үүсэх
- Хөрс бохирдох Ахуйн хатуу болон шингэн хог хаягдал, шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас хөрсөн бүрхэвч бохирдох
- Хог хаягдлаар хөрс бохирдох

Эдгээр хөрсөн бүрхэвч, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллүүдийг бууруулахаар 2025 оны БОМТ-д дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд хэрэгжилтийн биелэлтийг Хүснэгт 2-3-д тусгав. Үүнд:

- Тээвэрлэлтийн зам дагуу хурдны хязгаарлалтыг заасан тэмдэг тэмдэглэгээний элэгдэж гандсан хаяг шошгыг арчилж, тоос шороог цэвэрлэх
- Болзошгүй байдлаар шатах тослох материал асгарсан тохиолдолд хэрэглэх саармагжуулах иж бүрдлийн хэрэгслийг асгарсан тохиолдолд нэмж байрлуулах
- Хог хаягдлыг цэвэрлэх, бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах

Хүснэгт 2-3. Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Тээвэрлэлтийн зам дагуу хурдны хязгаарлалтыг заасан тэмдэг тэмдэглэгээний элэгдэж гандсан хаяг шошгыг арчилж, тоос шороог цэвэрлэх	Уурхайн тээврийн замын хурдны хязгаарлалтыг заасан тэмдэг, тэмдэглэгээний хаяг, шошгыг арчилж, зам дагуу тоос, шороог цэвэрлэсэн.	100%
2.	Болзошгүй байдлаар шатах тослох материал асгарсан тохиолдолд хэрэглэх саармагжуулах иж бүрдлийн хэрэгслийг асгарсан тохиолдолд нэмж байрлуулах	Шатах тослох материал асгарах магадлалтай тохиолдолд ашиглах саармагжуулах иж бүрдлийг нэмэлтээр байршуулсан.	100%
3.	Хог хаягдлыг цэвэрлэх, бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах	Уурхайн дотоод талбай болон орчны 50 метр радиуст 2025 онд нийт 10 удаа хог хаягдлын цэвэрлэгээ, бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулсан	100%
4.		Уурхайн орчмын 50 метр радиуст улирал бүр хог хаягдлыг цэвэрлэж, бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулсан.	100%
5.	Хог хаягдлыг 7. журмын дагуу хадгалж гэрээний дагуу тогтоосон хугацаанд тээвэрлэх	Хог хаягдлыг журмын дагуу хадгалж, хог тээвэрлэлтийн гэрээний дагуу тогтоосон хугацаанд тээвэрлэсэн	100%

Газрын гадарга, хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны холбогдох зургуудыг доор тусгалаа.



Зураг 2-3 Орчны цэвэрлэгээ хийгдэж байна

2.1.3 Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

БОННУ тайланд тусгаснаар Их Булангийн элс хайрганы ордын үйл ажиллагаанаас усан орчинд дараах гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг үзүүлэхээр байна. Үүнд:

- Ногоон байгууламжийн ургалт муудах

Хүснэгт 2-4. Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
		Лицензийн талбайд тарьсан модны усалгаа, арчилгаа, тордолгоог төлөвлөгөөний дагуу дараах хугацаанд хийв:	
1.	Ногоон байгууламжийн ургалт муудах	4 дүгээр сарын 20–5 дугаар сарын 1 хооронд — 1 удаа 5 дугаар сарын 1–6 дугаар сарын 1 хооронд — 4 удаа 6 дугаар сарын 15–8 дугаар сарын 15 хооронд — 9 удаа 8 дугаар сарын 15–9 дүгээр сарын 15 хооронд — 2 удаа Арчилгааны ажлыг тогтмол гүйцэтгэснээр тарьсан модны ургалт хэвийн, усалгааны үр дүн сайн байсан.	100%

Дархан хотын ТҮГ-тай байгуулсан Хог хаягдал тээвэрлэх болон Дархан-Ус суваг ХК-тай байгуулсан Цэвэр усаар хангах, бохир усыг татуулах гэрээг тайланд хавсаргав.

2.1.4 Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

БОННУ тайланд Их Булангийн элс хайрганы ордын үйл ажиллагаанаас 10.9 га талбай шүүд эвдрэл орох ба үржил шимт хөрс хуулах ажил хийгдэж ургамлан нөмрөг устгах сөрөг нөлөөллийг үзүүлэхээр байна гэж тусгасан байна.



Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахаар уурхайн ашиглалтын дараагаар биологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу хийж гүйцэтгэх ажлыг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд хэрэгжилтийн биелэлтийг Хүснэгт 2-5-д тусгав.

Хүснэгт 2-5. Ургамлан нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хэрэгжилт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
	Лицензийн болон уурхайн талбайд тарьсан модны усалгаа, арчилгаа, тордолгоог хийх	Лицензийн талбайн гадна болон уурхайн талбайд суулгасан нийт 430 ш модны арчилгаа, тордолгоог хийж тухай бүрд услав.	100%

2.2 НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Сонголон Хайрхан ХХК нь 2022 оны БОМТ-ний хүрээнд лицензийн талбайн зүүн хойд талд 220 ш, 2023 онд 100 ш агч, улиас, бургас, 2024 онд нэмж тарьсан 120 ширхэг мод, 2025 оны нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний хүрээнд уурхайн талбайд тариалсан нийт 430 ш модны арчилгаа тордолгоог тухай бүрд нь хийв.

Ногоон байгууламжийн төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг Хүснэгт 2-6-д тусгав.

Хүснэгт 2-6. Ногоон байгууламжийн төлөвлөгөөний хэрэгжилт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Төлөвлөгөөний хүрээнд суулгасан нийт 430 ш модны арчилгаа, тордолгоог гүйцэтгэх	Лицензийн талбайн гадна болон уурхайн талбайд суулгасан нийт 430 ш модны арчилгаа, тордолгоог хийж тухай бүрд услав.	100%

Төлөвлөгөөний дагуу суулгасан нийт моддыг услах, арчлах ажлын хүрээнд нийт 1,550,000 төгрөг зарцуулагдсан ба эдгээр зардал нь шаардлагатай техник, ажилчдын цалин болно.

Төлөвлөгөөний биелэлтийг доорх зурагт тусгав.



Зураг 2-4 Мод усалж буй процесс



2.3 БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны БОМТ-нд Их Булангийн элс хайрганы ордын биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутгийн удирдлага, мэргэжилтнүүдтэй зөвлөлдөж Орхон сумын Баян-Өлзийт багийн хуучин хогийн цэгийн 3 га талбайд нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөсөн байна.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг Хүснэгт 2-7-д тусгав.

Хүснэгт 2-7. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Их Булангийн элс, хайрганы ордын биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутгийн удирдлага болон холбогдох мэргэжилтнүүдтэй зөвлөлдөх үүлзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулахаар төлөвлөж байна. Энэхүү зөвлөлдөх үүлзалтын үеэр дүйцүүлэн хамгаалах ажлын цар хүрээ, хэрэгжилтийн газар, биотехникийн арга хэмжээ, ургамалжуулалтын төлөвлөгөөг тодорхойлох, орон нутгийн байгаль орчны бодлого, хэрэгцээ шаардлагатай үялдуулах чиглэлээр санал солилцоно.	Мөн дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, байгаль хамгааллын ач холбогдлыг олон нийтэд сурталчлах, цаашдын хамтын ажиллагааны хэлбэрийг тодорхойлох зорилгоор хамтран ажиллах санамж бичиг байгуулах боломжийг судалж байна. Уулзалтын дараа гарсан санал, зөвлөмжид үндэслэн биологийн олон янз байдлыг хамгаалах ажлын нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулж, холбогдох байгууллагуудаар батлуулах, хэрэгжилтийн ажлыг үе шаттайгаар зохион байгуулахаар зорьж байна.	100%

2.4 НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Их Булангийн элс хайрганы ордын талбай орчимд эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд орших иргэд, айл өрхүүд байхгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг төлөвлөөгүй болно.

2.5 ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Сонголон Хайрхан ХХК нь Улаанбаатар их сургуулийн Түүх, археологийн тэнхимээр 2021 онд Археологийн авран хамгаалах хайгуул судалгааны ажлын тайланг боловсруулсан бөгөөд тус тайланд “Талбайд хайгуулын ажлыг хийж гүйцэтгэхэд ямар нэгэн археологи, түүхийн дурсгал илэрч олдоогүй. Хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэх үед талбайн ихэнх хэсэгт газар шорооны ажил гүйцэтгэж, хөрс хуулснаас гадна хиймэл усан сан үүсгэсэн байна. Усан сангийн талбайн доор болон газар шорооны ажлын явцад түүх соёлын ямар нэг дурсгал сүйдсэн, устсан байхыг үгүйсгэх аргагүй юм. Тиймээс цаашид Сонголон хайрхан ХХК нь хөрс шорооны ажлын явцад түүх соёлын дурсгал илрэн олдвол нэн даруй, зохих хууль ёсны дагуу мэргэжлийн байгууллагад хандан хамтран ажиллах”-ыг зөвлөсөн байна.

Мөн ШУА-ийн Палеонтологийн хүрээлэнгээр Палеонтологи судалгааны ажил хийлгүүлсэн бөгөөд 2021.10.11-ний өдрийн № Т/83 тоот дүгнэлтэй. Тус дүгнэлтэд “Судалгааны талбайн хэмжээнд дөрөвдөгч, орчин үеийн насны элс, шавар, шавранцар, хайрга, конглометар, гравелит, тунамал терриген хурдас чулуулаг тархсан ба хурдас чулуулгаас эртний шим ертөнцийн олдвор илрээгүй тул цаашид тусгай зөвшөөрлийн ажил явуулахад татгалзах зүйлгүй” гэж дүгнэсэн байна. Иймд Сонголон Хайрхан ХХК нь 2025 онд түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлагагүй.



2.6 ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Сонголон Хайрхан ХХК-ийн 2022 онд батлагдсан БОННУ-ний тайлангийн 5 жилийн БОМТ-ний осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөнд нийт 3 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Сонголон Хайрхан ХХК нь осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд 2025 он хүртэлх хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэн, тогтмол хэрэгжүүлж байна. Үүнд:

- Гал унтраах багаж, хэрэгслийг кемпийн баруун үрд талд байрлуулсан.
- Уурхайд ажилчдыг ХАБЭА сургалтыг хамруулдаг.
- 2022 оны төлөвлөгөөнд тусгасны дагуу ажилчдыг Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн Поликлиник-тэй хамтран эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан.
- Уурхайн кемпэд анхны тусламжийн эмийн санг байрлуулсан. 2025 оны осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг Хүснэгт 2-8-д тусгав.

Хүснэгт 2-8. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Хөдөлмөрийн аюулгүй байдлын талаар давтан зааварчилгааг мөрдүүлж ажиллах	Хөдөлмөрийн аюулгүй байдлын давтан зааварчилгааг бүрэн хэрэгжүүлж ажилласан.	100%
2.	Ажилчдыг үргэлжлүүлэн ХАБЭА сургалтад хамруулах	Ажилчдыг ХАБЭА-ийн сургалтад тогтмол хамруулсан.	100%
3.	Уурхайн галын хорыг цэнэглэж, ажиллагааг хангах	Уурхайн галын хорыг бүрэн цэнэглэж, хэвийн ажиллагааг хангаж ажилласан.	100%

Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний хүрээнд гүйцэтгэсэн ажлын холбогдох зургийг доор тусгав.



Зураг 2-5. Ажилчд сургалтад хамрагдаж байгаа байдал



Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Зураг 2-6 Ажилчдын эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байдал

2.7 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны БОМТ-нд хог хаягдлын менежментийн төлөвлөгөөнд ахуйн болон аюултай хог хаягдал үүсэхээс сэргийлж, дараах ажлуудыг төлөвлөсөн байна. Үүнд:

- Ахуйн хог хаягдлыг гэрээт байгууллагад тээвэрлүүлж, актаар хүлээлгэж өгөх
- Хог хаягдлын бүртгэлийг өдөр бүр хөтөлж ажиллах
- Хогийн сав болон цэгийг тогтмол цэвэрлэж, цэвэр байдлыг хангаж ажиллах
- Тээврийн хэрэгслийн ашиглалтаас гарсан дугуй, тоормосны шингэн, түлшний тос, түлш хийсэн хуванцар сав зэрэг аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагад нийлүүлж, устгуулах

2025 оны хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг Хүснэгт 2-9-д тусгав.

Хүснэгт 2-9. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Ахуйн хог хаягдлыг гэрээт байгууллагад тээвэрлүүлж, актаар хүлээлгэж өгөх	Ахуйн хог хаягдлыг гэрээт байгууллагад аюулгүй тээвэрлүүлж, актаар хүлээлгэн өгсөн.	
2.	Хог хаягдлын бүртгэлийг өдөр бүр хөтөлж ажиллах	Хог хаягдлын бүртгэлийг өдөр бүр нарийвчлан хөтөлж, шаардлагатай тайлан, мэдээг бүрэн бэлдсэн.	



Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
3.	Хогийн сав болон цэгийг тогтмол цэвэрлэж, цэвэр байдлыг хангаж ажиллах	Хогийн сав болон хогийн цэгийг тогтмол цэвэрлэж, орчны эрүүл ахуй, аюулгүй байдлыг бүрэн хангаж ажилласан.	
4.	Тээврийн хэрэгслийн ашиглалтаас гарсан дугуй, тоормосны шингэн, түлшний тос, түлш хийсэн хуванцар сав зэрэг аюултай хог хаягдлыг эрх бүхий байгууллагад нийлүүлж, устгуулах		

Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлтийг доорх зурагт тусгав.




Зураг 2-8 Хог хаягдал тээвэрлэх байгууллагад төлсөн баримт



Зураг 2-7 Хогийн цэг, түүний ойр орчим цэвэрлэгээ хийж буй байдал



Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 2-9. Хог хаягдал тээвэрлэх хамтран ажиллах гэрээ

Он, сар, Өдөр	Нэр төрөл	Тайлбар
2024 - 4 сар	Авгуйн хог	0,5 тн
2024 - 5 сар	Авгуйн хог, техникийн хог	1 тн
2024 - 6 сар	Авгуйн хог, техникийн хог	0,5 - 1 тн
2024 - 7 сар	Авгуйн хог, техникийн хог	0,5 тн - 0,8 тн
2024 - 8 сар	Авгуйн хог, техникийн хог	0,8 тн
2024 - 9 сар	Авгуйн хог, техникийн хог	0,2 тн - 0,4 тн
2024 - 10 сар	Авгуйн хог	0,2 тн
2025 - 4 сар	Авгуйн хог, техникийн хог	1 тн
2025 - 5 сар	Авгуйн хог, техникийн хог	0,5 тн
2025 - 6 сар	Авгуйн хог, техникийн хог	0,2 тн
2025 - 7 сар	Авгуйн хог	0,5 тн
2025 - 8 сар	Авгуйн хог, техникийн хог	1 тн
2025 - 9 сар	Авгуйн хог	0,5 тн
2025 - 10 сар	Авгуйн хог, техникийн хог	0,5 - 0,5 тн

Зураг 2-10. Хог хаягдлын бүртгэлийн хуудас

2.8 ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Их Булангийн элс, хайрганы ордын 2025 оны үйл ажиллагааны хүрээнд орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийг дараах чиглэл, үйл ажиллагааны дагуу хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Үүнд:

- Дотоод хяналт шинжилгээний хөтөлбөр буюу Сонголон Хайрхан ХХК нь уурхайн үйл ажиллагаанаас бий болж буй үр дагавруудыг хянах, илрүүлэх зорилгоор уурхайн талбайд агаар, хөрс, усны шинжилгээг хийх
- Уурхайн талбайд ургамал ургалтын үед, ургамлын судалгааг хийх
- Гадаад буюу хөндлөнгийн хяналт шинжилгээний хөтөлбөр буюу хөндлөнгийн хяналт шинжилгээний байгууллагаар орчны хяналт шинжилгээг хийлгэх, дотоод хяналт шинжилгээтэй харьцуулах, дүгнэх

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилтийн биелэлтийг Хүснэгт 2-10-д тусгав.

Хүснэгт 2-10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
1.	Агаарт орчны тоосжилт (PM2.5, PM10 TSP) болон агаар бохирдуулагч хий (SO2, NO2,) тодорхойлуулах	Дархан уул аймгийн “Ус Цаг Уур, Орчны Шинжилгээний Төв Байгаль Орчны Шинжилгээний Лаборатори” 8-р сард DustTrack DRX aerosol monitor 8533 багажийг ашиглан агаарт агуулагдах PM2.5, PM-10 болон нийт тоосонцор болон дуу чимээний хэмжилтийг хийж гүйцэтгэсэн.	100%



Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлт
2.	Хөрсний ерөнхий химийн үзүүлэлт болон хүнд металлыг 3 цэгт тодорхойлуулах	Дархан уул аймгийн “Ус Цаг Уур, Орчны Шинжилгээний Төв Байгаль Орчны Шинжилгээний Лаборатори” 2025 оны 8-р сард элсэн карьер, бутлуурын ойр орчимд 2 дээж авч шинжилсэн.	100%
3.	Тогтсон шүүрлийн усанд усны химийн шинжилгээг хийх	2025 оны 8-р сард мөн шүүрлийн уснаас дээж авч, Дархан уул аймгийн “Ус Цаг Уур, Орчны Шинжилгээний Төв Байгаль Орчны Шинжилгээний Лаборатори” тогтсон нуурын шүүрлийн усанд химийн шинжилгээг хийсэн.	100%

Агаарын чанар.

- Энэ жил ч мөн уурхайн агаарыг Дархан-Уул аймгийн Ус цаг уур, Орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораториор үйлдвэрийн агаарыг шинжлүүлэхэд агаарт агуулагдах хүхэрлэг хий, азотын давхар исэл болон нийт тоосны агууламж нь агаарын чанарын MNS: 4585:2016. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага стандартын 1 удаагийн сорьцын хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт байхгүй байна.

2025 оны 08 сарын 19-ний өдөр авсан агаарын хэмжилтийн үр дүнг Хүснэгт 2-11-т тусгав.

Хүснэгт 2-11. Уурхайн орчимд хийсэн агаарын хэмжилтийн үр дүн

Үзүүлэлт	Хүхэрлэг хий /SO ₂ /	Азотын давхар исэл (NO ₂)	Нийт тоосонцор (TSP)
Элсэн карьерийн орчин	3	16	51
Бутлуурын орчин	16	38	342
MNS 4585:2016	450	200	500

Уурхайн бутлуур орчмын агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар исэл, нийт тоосны агууламжийг доорх графикт тусгав.




График 2-1. Уурхайд хийгдсэн хүхэрлэг хийн агууламж




График 2-2. Уурхайд хийгдсэн азотын давхар ислийн агууламж




График 2-3. Уурхайд хэмжигдсэн нийт тоосны агууламж

Уурхай орчмын агаар дахь хүхэрлэг хий, азотын давхар исэл нь агаарын чанарын MNS: 4585:2016. Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага стандартын 1 удаагийн сорьцын хүлцэх агууламжаас мөн л давсан үзүүлэлтгүй байна.

2. 2025 оны 8-р сард уурхайн талбайд агаарын хэмжилтийг *DustTrack 850* загварын багажаар агаарт агуулагдах тоосонцрын хэмжилтийг хийж гүйцэтгэсэн.



Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан



Зураг 2-11. Агаарын чанарын хэмжилт, 8 сар

Хүснэгт 2-12. Агаарын хэмжилтийн дүн, 8-р сар

Үзүүлэлт	Агаарын чийгшил	Агаарын температур	Салхины хурд
Элсэн карьерийн орчин	24-30%	23.2-24.5°C	Баруун өмнөөс 4м/с

Хөрсөн бүрхэвч

2025 оны БОМТ-нд Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрт тусгасны дагуу хөрсний дээжийг хөрсний ерөнхий химийн үзүүлэлтийг шинжлүүлэх зэрэг ажлын дагуу 2025 оны 8 дугаар сард карьер болон бутлуурын орчноос хөрсний дээжийг авч хөрсний ерөнхий химийн үзүүлэлтийг Дархан уул аймгийн “Ус Цаг Уур, Орчны Шинжилгээний Төв Байгаль Орчны Шинжилгээний лаборатори”-иор шинжлүүлсэн.

Хүснэгт 2-13. Уурхайн талбайгаас авсан хөрсний дээжийн хариу

Шинжилгээний аргын стандарт	Хөрсний химийн шинжилгээний үзүүлэлт	Хэмжих нэгж	MNS 3297:2019	Элсэн карьерийн орчин	Бутлуурын орчин
MNS 3310:91	Хөрсний ялзмаг	%	-	1.65	0.85
	Нитрат, NO ₃	мг/кг	130	6.1	2.7
	Сульфат, SO ₄	мг/кг	160	32.8	11.6
	Аммоний, NH ₄	мг/кг	-	37.1	10.4
	Фосфор, P ₂ O ₅	мг/кг	-	6.5	4.5
	pH	-	-	8.61	8.34
	ЕС	µS/cm	-	315.0	197.2



Зураг 2-12 Хөрсний дээж




График 2-4. Хөрсөнд агуулагдах Нитратын хэмжээ




График 2-5. Хөрсөнд агуулагдах Сульфатын хэмжээ

Уг жилд ч мөн хөрсний сорьц дээжийг диагоналийн аргаар авсан ба тухайн дээжийн хариунд, хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх MNS 3297:2019 стандарт дахь хөрсний эрүүл ахуйн шаардлагын химийн үзүүлэлтээр нитрат / NO_3 /-ын агууламж зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс даваагүй байна.

Ургамлан нөмрөг.

1. Уурхайн талбайд 6-р сард вегетацийн бичиглэл хийсэн.



Зураг 2-13. Ургамлын мониторинг хийх явц

Талбайд 1х1 метр квадрат хэмжээтэй Раменскийн торыг ашиглан Браунбланкийн арга зүйд тулгуурлан геоботаникийн бичиглэл хийж ургамлын зүйлийн бүрдэл, тусгагийн бүрхцийг тодорхойлсон. 1х1 квадрат метр талбайд:

- ургамлан бүрхэц 85 орчим хувь,
- чулууны бүрхэц 3 хувь,
- хагдны бүрхэц 4 хувь,
- халцгай газрын бүрхэц 8 хувь байсан.

Карьерын талбайн орчимд бүртгэгдсэн ургамлын жагсаалтыг Хүснэгт 2-14-д тусгав.

Хүснэгт 2-14. Карьерын талбайн орчимд бүртгэгдсэн ургамлын жагсаалт

№	Ургамлын монгол нэр	Ургамлын латин нэр	Найлзуурын өндөр, см	Фенологийн үе шат
Amaranthaceae				
1.	Сибирь шорной	<i>Atriplex sibirica</i> L.	9.3	Ургалтын үе
2.	Баг хуш хамхаг	<i>Halogeton glomeratus</i> (M. B.) C. A. Mey	3.4	Ургалтын үе
Asteraceae				
3.	Маралхай шарилж	<i>Artemisia tanacetifolia</i> L.	7.6	Ургалтын үе
4.	Эмийн бамбай	<i>Taraxacum officinale</i> Wigg.	14	Цэцэглэлтийн үе
Brassicaceae				
5.	Бүтэн навчит багдай	<i>Dontostemon integrifolius</i> (L.) C.A.Mey.	6.9	Цэцэглэлтийн үе
Chenopodiaceae				
6.	Цагаан лууль	<i>Chenopodium album</i> L.	3.2	Ургалтын үе
Cyperaceae				
7.	Ширэг улалж	<i>Carex duriuscula</i> C.A.Mey	18	Ургалтын үе
8.	Бага улалж	<i>Carex parva</i> Nees	5.7	Ургалтын үе
Iridaceae				
9.	Бар цоохор цахилдаг	<i>Iris tigrida</i> Bge.	8.5	Цэцэглэлтийн үе
Plantaginaceae				
10.	Их таван салаа	<i>Plantago major</i> L.	6.3	Ургалтын үе
Poaceae				
11.	Гялгар дэрс	<i>Achnatherum splendens</i> (Trin.) Nevski	60	Ургалтын үе
12.	Мөлхөө хиаг	<i>Agropyron repens</i> (L.) P. B.	21	Ургалтын үе
13.	Нарийн цагаан суль	<i>Elymus angustus</i> Trin	12.7	Ургалтын үе
Rosaceae				
14.	Ишгүй гичгэнэ	<i>Potentilla acaulis</i> L.	2.8	Ургалтын үе



Карьерын талбай нь голын хөндий, нам дор газар бөгөөд дэрс-улалжит бүлгэмдэл зонхилж ургасан. Талбайд 9 овгийн 13 төрлийн 14 зүйл дээд ургамал бүртгэгдсэн. Талбайд ховор болон нэн ховор ургамал бүртгэгдээгүй.

Усан орчин.

2025 оны БОМТ-ны орчны хяналт шинжилгээний усны чанарт тогтсон нуурын усны химийн шинжилгээний ажлын хүрээнд 2025 оны 04 сард Карьерийн шүүрэлтийн уснаас дээж авч Дархан уул аймгийн “Ус Цаг Уур, Орчны Шинжилгээний Төв Байгаль Орчны Шинжилгээний Лаборатори”-иор шинжлүүлсэн.

№	Шинжилгээний аргачлал	Усны химийн шинжилгээний үзүүлэлт	Хэмжих нэгж	MNS 6148:2010	Карьерийн шүүрэлтийн ус 2024 он	Карьерийн шүүрэлтийн ус 2025 он
1	MNS 1097:1970	Ca ⁺ /кальци/	мг/л	-	54.9	68.5
2	MNS 1097:1970	Mg ⁺ /манги/	мг/л	-	38.8	29.5
3	MNS 1097:1970	Na ⁺ +K ⁺ /натри кали/	мг/л	-	119.8	25.0
4	MNS 6832:2020	HCO ₃ /гидрокарбонат/	мг/л	-	283.2	166.0
5	MNS 6271:2011	SO ₄ /Сүльфат/	мг/л	500	135.4	4.2
6	MNS 4424:2005	Cl /Хлорид/	мг/л	350	57.4	40.1
7	MNS 1097:1970	Нийт эрдэсжилт	мг/л	-	789.5	272.3
8	MNS ISO 11923:2001	Жинлэгдэх бодис	мг/л	-	16.7	30.0
9	MN ISO 6059:2005	Хатуулаг /Ca Mg/	мг-экв/л	-	5.93	4.94
10	MN ISO 8467:1999	NH ₄ /аммони/	мгN/л	3.0	0.28	0.31
11	MNS 7150-1:2006	NO ₂ /нитрит/	мгN/л	1.0	0.011	0.005
12	MNS 1097:1970	NO ₃ /нитрат/	мгN/л	50.0	0.05	0.30
13	MN ISO 6878:2001	Рерд /ортофосфат/	мгP/л	3.5	0.078	0.095
14	MNS 6272:2001	F /фтор/	мг/л	-	0.51	1.09
15	MNS 4430:2005	Fe /төмөр/	мг/л	0.30	0.04	0.12
16	MNS ISO 10523:2001	pH/усны орчин/	-	6.5-8.5	7.76	8.45
17	MNS ISO 7888:1999	ЕС /ЦДЧ/	μS/cm	-	952.0	352.0
18	MNS ISO 11083:2001	Cr-VI /6 валентат хром/	мг/л	0.005	Илрээгүй	Илрээгүй
19	MNS ISO 8467:1999	Перманганатын исэлдэх чанар	мг/л	-	7.1	5.6

Дээрх дүнгээс үзэхэд MNS 6148:2010 Усны чанар. Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс давсан үзүүлэлт энэ жил мөн л байхгүй байна.

2.9 УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2025 оны БОМТ-нд тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу жилд нэг удаа мэргэжлийн байгууллагатай хамтран ажилчдад ХАБЭА-ын сургалт зохион байгуулж, уурхайн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдлэгийг дээшлүүлэх, осол, эрсдэлийг бууруулахад чиглэсэн. Үүнтэй зэрэгцэн ажилчдыг тогтмол хугацаанд эрүүл мэндийн үзлэгт хамруулж, эрүүл мэндийн байдалд хяналт тавих, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн.



Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Мөн уурхайн байгаль орчны удирдлагын тогтолцоог сайжруулах зорилгоор байгаль орчны аудитыг хэрэгжүүлж, төлөвлөгөөний хэрэгжилт, байгаль орчинд үзүүлж буй нөлөөллийг үнэлэн, шаардлагатай сайжруулалт, засварын арга хэмжээг тодорхойлох байв. Үүнээс гадна жил бүрийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) шинэчлэн боловсруулж, Дархан-Уул аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраар батлуулан, биелэлтийн тайланг хугацаанд нь хүргүүлж ажиллана.

2025 оны удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийн биелэлтийг Хүснэгт 2-15-д тусгав.

Хүснэгт 2-15. Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжүүлэлт	Биелэлтийн хувь
1.	Жилд 1 удаа мэргэжлийн байгууллагатай хамтран ажилчдад ХАБЭА сургалт зохион байгуулах	2025 оны БОМТ-нд тусгагдсан удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу жилд нэг удаа мэргэжлийн байгууллагатай хамтран ажилчдад ХАБЭА-ын сургалт амжилттай зохион байгуулж, уурхайн нийт ажилчдын хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн мэдлэг, үр чадварыг дээшлүүлэв. Үүний үр дүнд ажлын байрны эрсдэлийг бууруулах, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бодит ахиц гарсан.	100%
2.	Ажилчдыг үргэлжлүүлж эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Ажилчдыг тогтмол хугацаанд эрүүл мэндийн үзлэгт бүрэн хамруулж, эрүүл мэндийн байдалд хяналт тавьж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлээ. Үзлэгийн дүнгээс шалтгаалан зарим ажилчдад шаардлагатай зөвлөмж, чиглэл өгч, хөдөлмөрийн чадварыг хамгаалах, сайжруулах үйл ажиллагаа хэрэгжсэн.	100%
3.	Байгаль орчны аудит	Мөн уурхайн байгаль орчны менежментийн тогтолцоог үнэлэх зорилгоор байгаль орчны аудитыг амжилттай хийж гүйцэтгэсэн бөгөөд аудитын дүгнэлтээр уурхайн үйл ажиллагаа нь холбогдох хууль тогтоомж, стандартын шаардлагад нийцэж байгааг баталгаажуулсан.	100%
4.	Жил бүр БОМТ-г батлуулж, биелэлтийн тайланг Дархан-Уул аймгийн БОАЖГ-т хүргүүлэх	Жил бүрийн уламжлал ёсоор Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) шинэчлэн боловсруулж, Дархан-Уул аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраар батлуулан, биелэлтийн тайланг хугацаанд нь хүргүүлсэн.	100%

Сонголон Хайрхан ХХК нь улирал бүр Бетон зуурмагийн үйлдвэрийн ажилчид болон уурхайн ажилчдыг нэгтгэн оффис дээрээ сургалтыг зохион байгуулдаг.

Удирдлага зохион байгуулалтын менежментийн төлөвлөгөөний биелэлтийг доор тусгав.



Дархан-Уул аймгийн Дархан, Орхон сумдын нутагт байрлах Сонголон Хайрхан ХХК-ийн Их Булангийн элс хайрганы ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Зураг 2-14 Ажилчдын эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан хуудас



Зураг 2-15. Ажилчдад сургалтад хамрагдаж буй байдал



ДҮГНЭЛТ

Сонголон Хайрхан ХХК нь Их Булангийн элс хайрганы ордын 2025 оны БОМТ-нд тусгагдсан ажлуудыг амжилттай хийж гүйцэтгэсэн байна. Тухайлбал:

- Уурхайн тээвэрлэлтийн замын тоосжилтыг бууруулахын тулд усалгаа хийв
- Уурхайд хэрэглэгдэж буй тээврийн хэрэгслээс ялгарах хорт утааг стандартын түвшинд байлгах, хуваарьт үзлэг, оношилгоонд тогтмол хамруулах
- Хог хаягдлыг Дархан хотын Тохижилт үйлчилгээний газартай байгуулсан гэрээний дагуу сар бүр тогтмол тээвэрлүүлдэг бөгөөд хог хаягдлын бүртгэл хөтөлдөг.
- Лицензийн болон уурхайн талбайд тарьсан модны усалгаа, арчилгаа, тордолгоог хийх
- Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд тусгагдсан бүх ажлыг хэрэгжүүлсэн
- Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн Поликлиник-тэй хамтран компанийн ажилчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийн гэрээ байгуулсны дагуу ажилчдыг үзлэгт хамруулдаг байна.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсэг	Хийх ажлын тоо	Хийсэн ажлын тоо	Биелэлт (%)
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт	8	8	100
Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт	1	1	100
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	3	3	100
Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	4	4	100
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	3	3	100
Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	4	4	100
Нийт	23	23	100

Сонголон Хайрхан ХХК нь Их Булангийн элс хайрганы ордын 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан 23 ажлыг хийж гүйцэтгэн, 100 хувийн гүйцэтгэлтэйгээр амжилттай ажилласан байна.